

**ГХБХБГ-ЫН 2 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2018.01.31.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Энэ долоо хоногт 23 айлд газрын кадастрын хэмжилт хийсэн. Мөн ГХБХБГ-ын 2017 оны тайланг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>“Өлгий ланд” ХХК-ны булган сумд хийсэн 21, Дэлүүн сумд хийсэн 15, Улаанхус сумд хийсэн 7, ГХБХБГ-ын геодезийн мэргэжилтний Бугат сумд хийсэн 3, Өлгий сум хийсэн хашаан байшингийн 23 хэмжилтийг тус тус хүлээн авч шалгаж газрын кадастрын мэдээллийн санд оруулсан болно.</p> <p>Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын зориулалтыг өөрчилж нийтийн орон сууцны зориулалтаар газар эзэмших хүсэлт ирүүлсэн 1, Эзэмшиж байгаа газрын нэгж талбарыг хоёр хувааж нийтийн орон сууцны зориулалттай болгох нэг хүсэлтийг тус тус хүлээн авч холбогдох материалыг бүрдүүлж Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан ЗДТГ-рт хүргүүлэв.</p> <p>Өлгий сумын 50 хүүхдийн эмнэлэг, сургууль цэцэрлэгийн цогцолборын байршлыг судлав.</p> <p>Уул уурхайн нөлөөллөөс эвдэрсэн, нөхөн сэргээгдсэн, цаашид нөхөн сэргээлт хийх шаардлагатай газрын мэдээ, судалгааг гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлэн ажиллав.</p> <p>Сумдын газрын даамлуудад хүлээлгэн өгсөн гэр интернетийн төхөөрөмжөөс гарч буй асуудлыг хугацаа алдалгүй шийдвэрлэж ажилласан.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. Тухайлбал:</p> <p>Алтанцөгц сум: 37 иргэний хувийн хэргийг сканердаж ЛМ-</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

д оруулав.

4 иргэнд гэрээ хийж, гэрчилгээ олгож, байршлыг тогтоож координат авч ЛМ-д оруулж түр нэгж талбар үүсгэв.

Гэрчилгээ авсан 4 иргэнийг Улсын бүртгэлд бүртгэв.

Кадастрын өөрчлөлт хийж дуусгавар болгосон нэг иргэний материалыг ЛМ-д оруулж холбож өгөв.

10ш өргөдөл хүлээн авч танилцан захирамж төлөвлөв.

Бугат сум: Газар эзэмших захирамж гаргуулав. 1 айлын газрын байршлыг тодруулж ажиллаа. 2 иргэнд үл хөдлөх хөрөнгийн материал бүрдүүлж өгөв. ГХБХБГ-т 2 айлын нэгж талбарын зураг холбуулсан. Газрын төлбөрт 20000₮ оруулав.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР